

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН
ОРОС ХЭЛНИЙ БАГШ ШААРИЙ ОВОГТОЙ УРАНЧИМЭГИЙН 2018-2019 ОНЫ
ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

I. ТӨЛӨВШИЛ

1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал
 - Хичээлийн шинэ жилийн үйл ажиллагаа.
 - Спорт буухиа-2018-д хөгжөөн дэмжигчээр оролцсон.
 - БМДИ, Байгаль орчны сургалт арга зүйн төвийн хамтарсан эко аялалд ОХУ-ын Иркутск хотод орчуулагчийн үүрэг гүйцэтгэн явж ирсэн.
 - Орос хэлний дүүрэг, нийслэлийн олимпиадад 12а ангийн сурагчдыг бэлтгэн оролцуулсан.
 - Сургуулийн багш нарын баярын үйл ажиллагаа
 - Багш нарын нэгдсэн хурал
 - Урлагийн наадамд удирдсан 8а ангиа бэлтгэн амжилттай оролцуулсан.
 - “Хоцрогчгүй, таслагчгүй хамт олон” аян
 - Мөсөн хотхоны нээлт
 - Шинэ жилийн үйл ажиллагаа
 - Чингэлтэй дүүргийн орос хэлний олимпиадыг сургууль дээрээ зохион байгуулах ажилд оролцсон.
 - Голомт банкнаас зохион байгуулсан санхүүгийн боловсролыг дэмжих аянд оролцсон.
 - Цагаан сарын золголт
 - Эцэг эхийн нээлттэй хаалганы өдөр
 - ОШУСТ-өөс зохион байгуулсан “Тотальный диктант” ОУ-ын үйл ажиллагаанд сурагчдаа оролцуулсан.
 - ОХУ-ын Засгийн газрын тэтгэлэгт сурагчдаа бүртгүүлж хамруулсан.
 - Хэлний өдөрлөг
 - Хэлний наадам-2019
 - НБГ-ын орос хэлний даалгаврын сан бүрдүүлэх багт тест хийсэн.
 - 8-12-р ангийн сурагчдыг орос хэлний ОУ-ын түвшинчлэлийн шалгалтанд бэлтгэн, ахлах ангид суурь мэдлэгийн түвшингийн материалыг 4 чадвараар боловсруулж авсан.

2. Дэгийн хэрэгжилт, дадал хэвшил суусан байдал
 - Даасан 8а ангийн сурагчид, тэдний эцэг эхэд сургууль дээр мөрдөх дэгийг нэгбүрчлэн танилцуулж, дэгийг баримтлан ажилласан. Ухаалаг утас сургууль дээр хэрэглэхгүй байх, охидууд үсээ боох, завсарлагааны үеийн дэгийг сахих, хичээл эхлэхээс 10 минутийн өмнө ангидаа орж байраа эзэлсэн байх, хичээлд хоцрохгүй, хүндэтгэх шалтгаангүйгээр хичээл таслахгүй байхад анхаарч ажиллалаа. Дэгийг мөрдөж ажилласнаар хоцрогчгүй хамт олон болон 2 удаа БАТЛАМЖ гардсан авсан.

- Хичээл орж буй 5а, 6а, 8а, 11а, 5ё, 6в, 6ё ангиудад дараахи дэгүүдийг мөрдөхөд анхаарч ажиллалаа.
 - Хичээлийн 40 минутын дэг
 - Сурагчийн дэг
 - Завсарлагааны дэг
 - Цайны газрын дэг
 - Өлгүүрийн дэг
3. Бусадтай харилцах зан чанар
- Дүрэмт хувцсаа тогтмол бүрэн өмсөхөд хэвшүүлсэн.
 - Хичээл эхлэхээс өмнө ангиа, самбараа арчиж бэлдсэн байх
 - Багши ангид орж ирэхэд эмх цэгцтэй байх, үймж шуугихгүй байхад хэвшүүлж байна.
 - Хичээлийн дэгийг баримталж, ярих, бусдад саад болохгүй байх, бие биенийхээ үгийг сонсох, нэгийхээ шаардлагыг хүлээж авах, хүндэтгэлтэй хандах, талархалаа илэрхийлэх, бүдүүлэг үг хэллэг хэрэглэхгүй, ангийн даргын үүрэг даалгаврыг биелүүлэх зэрэгт анхаарч ажиллаж, хэвшүүлсэн.
 - Мэргэжлийн багш нар, аж ахуйн ажилчид, үйлчлэгч нартай мэндэлж байх, тэдний ажлыг хүндэтгэх
 - Хамтран суралцах, бие биедээ туслах, мэддэг зүйлээ хэлж өгөх зэрэг нь сурагчдын сурах сонирхлыг төрүүлж, эвсэг, зорилго нэгтэй хамт олон бүрэлдэх түлхэц болсон.
4. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал хэвшил, зан чанарын байдал
- “Цайны их замаар” ОУ-ын хүүхдийн наадамд сурагчдыг илтгэл, гар зураг, IQ төрлөөр амжилттай оролцуулсан.
 - Дэлүүн болдогийн “Гэгээн зөн” яруу найргийн тэмцээнд 5 сурагч амжилттай оролцсон.
 - Дэлүүн болдогийн “Гэгээн зөн” яруу найргийн тэмцээнд ангиараа олны биелгээ хийж олны хүртээл болгосон.
 - 8а анги “Авъяаслаг-23” урлагийн наадамд дунд ангийн “Шилдэг анги”-иар шалгарсан.
 - Шинэ жилийн үйл ажиллагаанд зориулж ханын сонин гаргасан.
 - Орос ардын “Калинка” бүжиг дунд ангийн хамтлаг бүжгийн төрөлд 1-р байрт шалгарсан.
 - “Ухаалаг утасны зохистой хэрэглээ” сургуулийн 7-12-р ангийн сурагчдын дунд явагдсан илтгэлийн уралдаанд 8а ангийн сурагч Г.Соном-Янжмаа ахлагчтай баг 1-р байр, Г.Соном-Янжмаа “Шилдэг илтгэгч”-ээр тодорлоо.
 - Ангийн дарга нарын анхдугаар зөвлөгөөнд “Бид өөр өөр ертөнц” сэдэвт илтгэлийг ангийн дарга Э.Ану, Г.Ундармаа, Г.Соном-Янжмаа нар уншиж, өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэн оролцлоо.
 - Сурагч Г. Соном-Янжмаа, Ч.Эрдэнэ-Үжин нар сурагчдын хэлэлцүүлэгт оролцон, өөрийн үзэл бодлоо илэрхийллээ.
 - Голомт банкны санхүүгийн боловсрол олгох, “Хуримтлалыг багаас нь” сургалтыг ангидаа авч, 22 сурагч хуримтлалын дэвтэр нээлгэсэн.
 - Хэлний наадамд 8а анги “Детство” найрал дуугаар оролцсон.

- “Цайны их замаар” ОУ-ын хүүхдийн наадамд 8а анги хамт олноороо олны биелгээ бүжиглэн хүрэл медаль хүртсэн.
 - Замын цагдаагийн газрын нээлттэй хаалганы өдөр, “Бяцхан зорчигч- аяны нээлтийн үйл ажиллагаанд 8а анги хамт олноороо оролцон, сурагчид замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар өөрсдийн санаа бодлоо Eagle TV, ETV сувгуудад ярилцлага өгөн илэрхийллээ.
 - 8а ангийн сурагчид “Читаем сказки” үлгэр уншаад орчуулж үзэсгэлэн гаргасан.
5. Жижүүр багшийн үнэлгээ
Хичээлийн жилийн турш 5 удаа жижүүр багшийн үүрэгт ажлыг хариуцлагатайгаар хийсэн. 10 сарын 22-д жижүүр багш -20 оноо, 11 сарын 19 – 30 оноо, 12 сарын 19-30 оноо, 2 сарын 25 -24 оноо, 4 сарын 20-30 оноо.
6. Хэдэн судалгаа хийсэн, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал
Ангийн сурагчдаас дараахи судалгааг авлаа.
- Дэлгэрэнгүй судалгаа
 - Эрсдлийн судалгаа
 - Мэргэжлийн чиг баримжааны судалгаа
 - Авъяас сонирхлын судалгаа
 - Автобусны судалгаа
 - Цахим хэрэглээний судалгаа
7. Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн
- Багш-эцэг эх-сурагчийн гурвалсан гэрээ байгуулж, хагас жил, жилийн эцсээр дүгнэн ажиллаж байна.
 - Ухаалаг утас сургуулийн орчинд хэрэглэхгүй байх заавар зөвлөмжийг эцэг эхэд танилцуулан сурагчдын 81% нь товчлууртай утас хэрэглэх буюу ухаалаг утсаа сургууль дээр авч ирэхгүй болсон.
 - “Авъяаслаг-23” сургуулийн урлагийн наадамд бэлтгэх ажил, хувцасны жигдрэл гэх мэт бүх л ажлыг эцэг эхчүүд хариуцан ажиллалаа.
 - Сурагч Бадармаагийн аав, Дуулимын ээж, Мөнх-Анугийн аав нар шинэ жилийн бэлтгэл ажилд оролцон ангиа төлөөлөн спорт заалыг чимэглэлээ.
 - Эцэг эхийн нээлттэй хаалганы өдөрлөгөөр Л.Мишээлийн аав Л.Лувсанжамц “Эцэг эх гэж хэн бэ? Сургууль, хүүхэд, багшийн хамтын ажиллагаанд таны үүрэг оролцоо” сэдвээр илтгэл тавьж өндөр үнэлгээ авлаа.
 - Дүрслэх урлагийн музей, уран зургийн галерей орж зураач Даваанямын Мартын 8-нд зориулсан цэцгийн үзэсгэлэнг үзэх үйл ажиллагааг ангийн эцэг эхчүүд зохион байгуулсан.
 - “Сурагчдын эрүүл ахуй, хандлага, төлөвшил” сэдвээр II нэгдсэн эмнэлгийн эмч Баярмаа ахлагчтай 3 эмч, ажилтныг авчран сургалт явуулж,ярилцлага хийлээ.
 - “Ажил мэргэжлийн чиг баримжаа” сэдэвт эцэг эхэд зориулсан лекцэд сурагч Амартүвшингийн ээж, Амин-Эрдэнийн ээж, Дуулимын ээж, Мөнххүслэнгийн ээж, Оюун-Эрдэнийн аав, Нямгэрэлийн аав, Номингийн ээж нар оролцож, бусад эцэг эхчүүдэд мэдээллээ хуваалцлаа.
 - Эцэг эхийн Moodle сургалтанд Янжилхамын ээж Баасанхүү, Гэрэлийн ээж Мөнхтуяа нар хамрагдаж, эцэг эхийн хурлаар ангийн эцэг эхчүүдэд зааж сургалаа.

- Сургуулийн "School police"-ийн үүрэгт ажлыг хуваарийн дагуу сайн гүйцэтгэлээ.
- 8. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн биелэлт
Хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, үе тэнгийнхний дарамтаас сэргийлэх, хамгаалах, багшийн зүгээс ёс зүй баримтлахад анхаарч ажиллалаа.
- 9. Гранд дизайны зорилго, зорилтын биелэлт
 - Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд тэгш хамруулж, зөв хандлагад чиглүүлэн ажилласан. Хүүхдэд хайртай, бусадтай хамтран багаар ажиллах чадвараа хөгжүүлж, хариуцлагатай, сурагчдын түвшин, сонирхол хэрэгцээнд тохирсон хичээлийн хөтөлбөр хийж, эцэг эхтэй хамтран сургалт хүмүүжлийн үйл ажиллагаанд хичээн оролцлоо.
 - Сурагчдын өөрийн хөгжлийн төлөвлөгөөнд сургуулийн гранд дизайнд тусгасан заалтуудаас оруулж, дадал хэвшил болгоход зорин ажиллаж 1-р хагас жилд дүгнэсэн.

II. МЭДЛЭГ ЧАДВАР, АХИЦ, АМЖИЛТ

1. Гарааны болон оношлох үнэлгээ

6, 8. 11-р ангийн гарааны үнэлгээний материал боловсруулж үнэлсэн.

1-р хагас жилийн мэдлэг чадварын сорилтын дүнгийн нэгтгэл

| № | Анги бүлэг | Тоо | Түвшин | | | | | | | |
|------|------------|-----|--------|-----|----|----|----|-----|----|---|
| | | | VIII | VII | VI | V | IV | III | II | I |
| 1 | 6a | 30 | 0 | 5 | 3 | 11 | 5 | 4 | 1 | 1 |
| 2 | 8a | 46 | 2 | 11 | 11 | 11 | 8 | 1 | 2 | 0 |
| 3 | 11a | 18 | 0 | 5 | 5 | 3 | 1 | 3 | 0 | 1 |
| 4 | 12a | 26 | 1 | 4 | 5 | 6 | 7 | 3 | 0 | 0 |
| Нийт | | 120 | 3 | 25 | 24 | 31 | 21 | 11 | 3 | 2 |

Гарааны үнэлгээний сэдвийг өмнөх ангид үзэж байсан агуулгын хүрээнд боловсруулсан. Сурагчид зуны амралтаар зарим нэг агуулгыг мартсан байсан нь дүнгийн нэгтгэлээс харагдаж байсан. Үүнд дүн шинжилгээ хийж, анги бүрт мартагдсан дүрэм, үг зүйг сэргээн санах даалгавар хийлгэж мэдлэгийн бататгасан.

2. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /MOODLE/
8-р ангийн 3-р улирлын 2 нэгж хичээлийн хөтөлбөр, 6 ээлжит хичээл, 45 тест боловсруулан оруулсан.
3. Стандарт хэрэгжилт

| № | Анги бүлэг | Тоо | Түвшин | | | | | | | |
|---|------------|-----|--------|-----|----|---|----|-----|----|---|
| | | | VIII | VII | VI | V | IV | III | II | I |
| 1 | 6a | 31 | 8 | 14 | 7 | 2 | 0 | 0 | 0 | 0 |
| 2 | 8a | 23 | 11 | 7 | 5 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 3 | 11a | 20 | 10 | 10 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4 | 12a | 29 | 17 | 12 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 5 | 5a | 29 | 10 | 14 | 4 | 1 | 0 | 0 | 0 | 0 |

| | | | | | | | | | | |
|------|----|-----|----|----|----|---|---|---|---|---|
| 6 | 5ё | 31 | 14 | 8 | 9 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 7 | 6в | 30 | 9 | 10 | 11 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 8 | 6ё | 31 | 9 | 13 | 9 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Нийт | | 224 | 88 | 88 | 45 | 3 | 0 | 0 | 0 | 0 |

4. Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт
 - Орос хэлний хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө хийж, сурагчдын гарааны оношилгоо хийсэн.
 - Мэргэжлийн дагуу дүүрэг, нийслэлийн сургалт, семинарт цаг тухайд нь хамрагдсан. ОХУ-ын Ростов на Дону хотын их сургуулийн багш нарын “Орос хэл заах арга зүй” 72 цагийн сургалтанд хамрагдаж, заах арга зүй, хэл зүйн дүрэм, унших даалгавар гүйцэтгэх хичээлд сууж, сертификат авсан.
 - Сургуулийн сургалт, цэнэглэх цагт цаг тухайд нь суусан.
 - Сургууль дээр хэрэгжиж байгаа Мүүдл системийг хэрэглэж суралцан ашиглаж эхэлж байна.
 - Дотоод сүлжээ, ESIS.EDU.MN сайтад дүн оруулах зэрэг ажлыг тухай бүрт нь хийж гүйцэтгэсэн.
 - Удирдан ажиллаж буй 8а ангийн сурагчдад зөв хандлага, төлөвшил олгох ажилд анхаарч ажилласан.
 - Дэмжлэг хэрэгтэй сурагчидтай хамтран хичээллэсэн.
5. Судлагдахууны хөтөлбөрийн үр дүн
 - Орос хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 5а, 6а, 8а, 11а, 12а ангиудын 132 сурагч, хоёрдогч хэлбэрээр орос хэл судалж буй 5ё, 6в, 6ё ангиудын 92 сурагч, нийт 224 сурагчид орос хэлний сургалтыг стандартын дагуу хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан өглөө. 5-12 ангид гүнзгийрүүлэн нийт 770 цаг, энгийн 245 цаг, нийт 1015 цагийн хичээл заалаа.
 - Чингэлтэй дүүргийн гадаад хэлний судлагдахууны багийн ажилд тухай бүрт оролцож байсан. “Тамирчин багш -2019”-д хөгжөөн дэмжигч, орос хэлний үндсэн сургалтад хамрагдаж буй багш нарт хэлэлцүүлэгт хичээл заах Л.Мягмарсүрэн, Б.Алтанхуяг багш нарт хичээлийн хөтөлбөр боловсруулах, бэлтгэх ажилд тусаллаа.
6. Журнал бичилт
 - Анги удирдсан багшийн журналыг зааврын дагуу хөтөлж, сурагчдын дэлгэрэнгүй судалгаа, оношилгоо, ололт амжилтыг бичиж тэмдэглэлээ. Мөн дүнг нэгтгэн бичсэн.
 - Багшийн тэмдэглэл хэсэгт хэрхэн оролцсон байдал, төлөвшилд ямар өөрчөлт гарсан зэргийг тухай бүрт бичиж тэмдэглэсэн.
7. Хичээл ордог сурагчдын хүртээмж
 - Орос хэлийг гүнзгийрүүлэн судалж буй 5а, 6а, 8а, 11а, 12а ангиудын 132 сурагч, энгийн стандартаар судалж буй англи хэлний сургалттай 5ё, 6в, 6ё ангиудын 92 сурагч, нийт 224 сурагч хичээл орлоо. Өдөрт 5-7 цагийн хичээл заасан. Группээр ордог ч нийт ангийн хүүхдийн тоо их учир зарим ангиудад хичээл ороход хүндрэлтэй тал гардаг. Хүүхэд нэг бүрт хүрч ажиллахад анхаарч гэрийн даалгавар хийлтийг тогтмолжуулах, хичээлийн явцыг хичээл бүр дээр шалган

үнэлэхээр хичээн ажиллалаа. Шаардлагатай үед ангийн багшаар дамжуулан эцэг эхтэй холбогдон хамтран ажиллахыг зорилоо.

Хичээл заадаг ангиудын сурагчдын тоо:

| № | Анги бүлэг | Хүүхдийн тоо |
|---|------------|--------------|
| 1 | 5a | 29 |
| 2 | 6a | 31 |
| 3 | 8a | 23 |
| 4 | 11a | 20 |
| 5 | 12a | 29 |
| 6 | 5ё | 31 |
| 7 | 6в | 30 |
| 8 | 6ё | 31 |

8. Багшийн хөгжлийн дэвтэр хөтлөлт

- Багшийн хөгжлийн дэвтрийг өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын дагуу хөтлөн, хийсэн ажлаа дүгнэн бичиж, цаашид төлөвлөж байгаа ажлаа бичиж тэмдэглэж байлаа.
- Хийсэн ажлаа цаг тухайд нь бичиж байвал хэрэгтэй болохыг ойлголоо.
- Дэвтрийн хөтлөлтийг сургалтын албанд 1 удаа дүгнүүлсэн.

9. Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн бүтээлч ажил

- Энэ хичээлийн жилд сурагчдын сурах идэвхи сонирхлыг өрнүүлэх, багшийн үйл ажиллагааг чанартай болгох зорилготой секцийн зүгээс шинэ сурах бичиг хэрэглэж эхэлсэн нь маш үр нөлөөтэй ажил болсон. 3-4-р ангид “Солнышко-1” сурах бичиг, дасгал ажлын ном, 5-р ангид “Солнышко-2” сурах бичиг, дасгал ажлын нос, 8-9-р ангид “Жили были” ахисан анхан шатны ном, ажлын дэвтэр, CD, 10-12-р ангид “Жили были” дундаас ахисан дунд шатны сурах бичиг, ажлын дэвтэр, CD хэрэглэсэн.
- НБГ-ын даалгаврын санд тавигдсан жишиг даалгаврын дагуу хичээл ордог ангиуд болон даасан 8a ангийн сурагчдыг анги дэвших шалгалтанд мэргэжлийн багштай хамтран бэлтгүүлсэн.

10. Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал

- Сурагчдын мэдлэг чадварын ялгаатай байдлыг харгалзан үзэж, даалгаврыг оновчтой өгч, тулж ажилласан.
- Эцэг эхтэй уулзаж ярилцан, хамтран ажиллаж байсан.

III. Авъяасыг нээн судлах, хөгжүүлэх

1. Сонирхлын судалгаа

| № | Сонирхол | Сурагчдын тоо |
|---|---------------|---------------|
| 1 | Бүжиглэх | 34 |
| 2 | Дуулах | 15 |
| 3 | Хөгжим тоглох | 3 |
| 4 | Зураг зурах | 3 |

| | | |
|---|-------------------------|----|
| 5 | Аялах | 26 |
| 6 | Гадаад хэлээр хичээллэх | 12 |
| 7 | Спорт | 21 |
| 8 | Загвар, дизайн | 4 |
| 9 | Гар урлал | 3 |

Сурагчдынхаа сонирхол дээр тулгуурлан ажиллахад анхаарах болно.

2. Дугуйлан секцэд хамрагдсан сурагчдын судалгаа

| № | Дугуйлан секцийн нэр | Тоо |
|----|-------------------------|-----|
| 1 | Физик | 13 |
| 2 | Хими | 4 |
| 3 | Волейбол | 4 |
| 4 | Морин хуур | 1 |
| 5 | Загвар | 2 |
| 6 | Бассейн | 3 |
| 7 | Циркийн уран нугаралт | 1 |
| 8 | Бүжиг | 15 |
| 9 | Эко клуб | 2 |
| 10 | Мэтгэлцээний Логос клуб | 3 |
| 11 | Монгол бичиг | 6 |
| 12 | Сагсан бөмбөг | 1 |
| 13 | Гадаад хэл | 13 |
| 14 | Математик | 5 |

3. Ангийн номын сангийн баяжилт

- Орос үлгэр, хүүхдийн номоор ангийн номын санг баяжуулж, сурагчид энэ хичээлийн жил 1-2 үлгэр уншиж, тэмдэглэл хөтлөн, орчуулж, зургаар үйл явдлыг нь харуулсан үзэсгэлэн гаргасан.
- Сургуулийнхаа цахим номын санд 45 ном хандивласан.

4. Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх

- II улирлын амралтаар заавал унших номын нэрсийг өгч, хүүхэд бүр уншиж, хөтөлсөн тэмдэглэлийн дагуу зохиолын үйл явдлыг ангийнхандаа ярьж, хүмүүжил, төлөвшлийн ямар сургамжтай болох талаар хэлэлцэж, дүгнэж байсан.

5. Бүтээлийн үзэсгэлэн гаргасан эсэх

- Хэлний наадамд Хүүхдийн ордонд буюу сургууль дээрээ 8а ангийн сурагчид уншсан орос үлгэр, өгүүллэгийн орчуулга, зохиолынхоо үйл явдлыг илтгэсэн зураг зурж “Читаем сказки” үзэсгэлэн гаргасан.

6. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлсэн байдал

- “Хоцрогчгүй, таслагчгүй хамт олон” аяны хүрээнд сургуулийн дэгийг мөрдөн ажиллаж, 11-р сард дэд байр эзэлсэн БАТЛАМЖ, 4-р сард IV байр эзэлж БАТЛАМЖ гардан авсан. Сурагч бүр аянд идэвхтэй оролцон бие биедээ шаардлага тавин хичээн суралцсан.
- “Ухаалаг утасны зохистой хэрэглээ” 7-12-р ангийн сурагчдын дунд зохиогдсон багийн илтгэлийн уралдаанд Г.Соном-Янжмаа ахлагчтай 8а ангийн баг 1-р байр эзэлсэн. Мөн Г.Соном-Янжмаа шилдэг илтгэгчээр шалгарсан.

- “Цахим орчин бидний амьдралд” сэдэвт ханын сонины уралдаанд Ч.Эрдэнэ-үжин, Г.Ундармаа ахлагчтай багууд амжилттай оролцон 2-р байр эзэлсэн.
- Ангийн дарга нарын анхдугаар зөвлөгөөнд ангийн дарга Э.Ану, Г.Ундармаа, Г. Соном-Янжмаа нар “Бид өөр өөр ертөнц” сэдэвт илтгэлээр оролцон, өөрсдийн үзэл бодлоо бусдад түгээн хүргэлээ.
- Сурагч Б.Есүй хэлний наадам-2019 –д Буратино дууг дуулан оролцлоо.
- Сурагч Э.Ананд, Б.Эгшиглэн, Б.Энхсолонго, Б.Номин, Г.Соном-Янжмаа нар Дэлүүн болдогийн Гэгээн зөн яруу найргийн уралдаанд амжилттай оролцсон.
- Сургуулийн хөл бөмбөгийн аваргын тэмцээнд хөвгүүд амжилттай оролцож, 2 хожил авсан.
- Сургуулийн шатрын аварга шалгаруулах тэмцээнд Г.Соном-Янжмаа тусгай байр, “Уран нүүдэлч” өргөмжлөл авсан.
- Сурагч Б.Амартүвшин ЧД-ийн шатрын аварга шалгаруулах тэмцээнд хүрэл медаль, “OPEN РЦНК” шатрын тэмцээнд 5-р байрт шалгарсан.
- Сурагч Б.Мягмаржаргал БНХАУ-ын Эрээн хотод болсон “Цайны их замаар” ОУ-ын хүүхдийн наадамд “Залуу хөтөч” төрөлд орос хэлээр илтгэл уншин мөнгөн медаль авсан.
- Сурагч Б.Янжинлхам Цайны их замаар” ОУ-ын хүүхдийн наадамд “Залуу хөтөч” төрөлд орос хэлээр илтгэл уншин хүрэл медаль авсан.
- Сурагч Г.Соном-Янжмаа Цайны их замаар” ОУ-ын хүүхдийн наадамд “Залуу хөтөч” төрөлд орос хэлээр илтгэл уншин хүрэл медаль авсан.
- Цайны их замаар” ОУ-ын хүүхдийн наадамд “IQ” төрөлд орос 8а ангийн сурагч Э.Ананд, О.Билгэ-Очир, О.Бэхи-Очир, Э.Оюун-Эрдэнэ, Б.Мягмаржаргал, Б.Энхсолонго, Б.Эгшиглэн нар мөнгөн медаль авсан.
- Цайны их замаар” ОУ-ын хүүхдийн наадамд “Залуу хөтөч” төрөлд Л.Мишээл, П.Намуун, Б.Бүжинлхам нар орос, англи хэлээр илтгэл уншин амжилттай оролцсон.

7. Олимпиад, уралдаан тэмцээн

| № | Сурагчийн нэр | Анги бүлэг | Мэргэжлийн хичээлүүдийн чиглэлээр олимпиад, уралдаан тэмцээн оролцсон байдал | | | |
|---|---------------|------------|--|---------|-----|---|
| | | | Дүүрэг | Нийслэл | Улс | Олон улс |
| 1 | Ш.Билэгт-Очир | 6а | | | | Цайны их зам ОУ-ын наадам илтгэл 1-р байр, алтан медаль |
| 2 | Н.Рэнцэндорж | 12а | Орос хэлний олимпиад-1-р байр | | | |
| 3 | М.Номуундарь | 12а | Орос хэлний олимпиад-2-р байр | | | |
| 4 | Ц.Удвал | 12а | Орос хэлний олимпиад-3-р байр | | | |
| 5 | М.Мөнхболор | 12а | | | | ОХУ-ын Халимагийн их |

| | | | | | | |
|---|----------------|----|--|--|--|--|
| | | | | | | сургуулийн олимпиад 1-р байр |
| 6 | Б.Мягмаржаргал | 8а | | | | Цайны их зам ОУ-ын наадам илтгэл 2-р байр, мөнгөн медаль |
| 7 | Б.Янжинлхам | 8а | | | | Цайны их зам ОУ-ын наадам илтгэл хошой мөнгөн медаль |
| 8 | Г.Соном-Янжмаа | 8а | | | | Цайны их зам ОУ-ын наадам илтгэл 2-р байр, мөнгөн медаль |

8. Бүтээлч ажил

НБГ-ын орос хэлний хичээлийн даалгаврын сан бүтээх багт сургуулиа төлөөлөн ажиллаж, 8-р ангийн ярих чадварын 100 тест, 10-р ангийн унших чадварын 50 тест хийж байршууллаа.

9. Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж, анги нийтээрээ хөгжсөн байдал

- 8а ангийн ардын бүжгийн “Уран бэхи” хамтлаг Сэвжидийн Сүхбаатарын нэрэмжит “Би бүжигчин болно” бүжгийн уралдаанд оролцож дүүрэгт 1-р байр
- “Уран бэхи” хамтлаг Гэгээн алсын одод” ТВ шоунд оролцсон.
- Цайны их замаар” ОУ-ын хүүхдийн наадамд ангиараа олны биелгээгээр оролцон хүрэл медаль авсан.
- Урлагийн боловсролыг дэмжих төвийн бүжгийн сургалтанд хамрагдсан 12 сурагч ангийнхаа бусад сурагчдад олны биелгээг заан сургаж Авъяаслаг-23 урлагийн наадамд бүжиглэн амжилттай оролцлоо.
- “Калинка” орос ардын бүжиг /12 сурагч/ дунд ангийн хамтлаг бүжгийн төрөлд 1-р байр эзэллээ.
- Хэлний наадамд 8а ангийн бүх сурагч “Детство” дууг дуулан оролцлоо.
- Голомт банкны санхүүгийн боловсролын сургалтанд ангиа хамрагдуулж “Хуримтлалыг багаасаа” төсөлд ангийн 22 сурагчийг хамруулан Голомт банкны ТАЛАРХАЛ гардан авсан.

10. Багш ажлын байран дээрээ хөгжсөн байдал

- Мүүдл системийн сургалтанд сууж, хичээлийн хөтөлбөр, тест, даалгавар оруулахад суралцсан.
- Мөн дотоод сүлжээнд дүн оруулах
- Хичээлээ цахим хэлбэрээр бэлтгэн зааж байна
- Сургуулийн захиргааны зүгээс багш нарын мэдлэг чадварыг цэнэглэх, эрүүл амьдрал, нийгмийн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхуулах зорилготой зохион байгуулдаг “Цэнэглэх цаг”-т оролцож байсан.
- НБГ-ын даалгаврын сан бүрдүүлэх санд 8-р ангийн 100 тест, 10-р ангийн 50 тест боловсруулсан.

IV. Боловсролын сэтгэл ханамж

1. Цаг ашиглалт.

- Тухайн хичээлийн жилд заах ёстой 1015 цагийн хичээлийг таслалтгүй заасан.
- Хичээл заах, цаг үеийн хурал шуурхайд оролцох, цэнэглэх цагт суух, журнал бичих, дэвтэр засах, тест засах, ангиа цэвэрлүүлэх, ангиа тараах
- Олимпиад, уралдаан тэмцээнд сурагчдыг бэлтгэх
- Эцэг эхийн хурал хийх
- Эцэг эхтэй ганцаарчлан уулзаж, арга зүйн зөвлөгөө өгөх
- Мүүдл сургалтанд хамрагдах, тест, даалгавар оруулах
- Судалгаа авах
- Хоцрогдсон сурагчидтай ажиллах
- Секцийн хурал, үйл ажиллагаанд оролцох

2. Сэтгэл ханамжийн судалгаа

- Сурагчдаас судалгаа авсан
- Эцэг эхчүүдээс авсан судалгаа нь орос хэлний хичээл дээр ярих чадварт түлхүү анхаарах шаардлагатай гэдэг дээр олон санал гарсан.

3. Хичээлийн цагийн хариуцлага -40 минут

Хичээлийг цагтаа эхэлж, цагтаа дуусгах, 40 минутыг үр бүтээлтэй, чанартай

4. Багшийн ёс зүй, хууль эрх зүйн биелэлт

Багшийн ёс зүй, хууль эрх зүйг баримтлан ажиллалаа.

5. Багшийн хичээлийн бэлтгэл

- Ээлжит хичээлийн бэлтгэлийг хийн, чанартай боловсролын үйлчилгээг ханган ажиллалаа.
- Нэгж хичээлийн хөтөлбөрийг улирал бүр боловсруулан сургалтын менежерээр батлуулан сургалтаа явууллаа.
- 6,8-р ангийн орос хэлний хичээлийн нэгж хичээлийг Мүүдл системд оруулсан.
- НБГ-ын даалгаврын сан бүрдүүлэх багт орж ажиллан 8,10-р ангийн тестийг боловсруулсан.

6. Хоцрогч таслагч сурагчидтай ажилласан байдал, үр дүн

- Хоцрогч таслагчгүй хамт олон” аянд 11-р сард дэд байр, 4-р сард IV байр эзэлж БАТЛАМЖ авсан.
- Сурагч Ш.Мөнххүслэн, М.Хишигдаваа, М.Мөнх-Ану нар хичээлд удаа дараалан хоцорч байсан. Эцэг эхтэй нь ярилцаж, сурагчидтай ярилцан амлалт аван хоцролт эрс багассан. Хүндэтгэх шалтгаангүйгээр хичээл таслалт байхгүй.

7. Багшийн сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал

- Багшийн журнал, анги удирдсан багшийн дэвтрийг чиглэл бүрээр хөтөлж тэмдэглэсэн. Багшийн хөгжлийн дэвтрийг хөтөлсөн. Сурагчийн хувийн хэргийг журмын дагуу хөтлөн хичээлийн жилийн эцэст сургалтын менежерээр хянуулан баталгаажуулж байна.

8. Сургалтын техник хэрэгслийг ашигласан байдал

- Цахим хичээлийг бэлтгэн явуулж байсан.
- Мүүдл системд хичээл оруулсан.

- Ангийн зурагтыг HDMI холболтоор холбон мэргэжлийн багш нарт цахим хичээл заах боломжийг хангасан.
9. Сурагчдын хөгжил төлөвшил эрсдлийн судалгааны сан бүрдэлт
- Эрсдэлд өртөж болзошгүй сурагчийн судалгаа гаргасан. РС тоглодог П.Од, Г.Гэрэл, Б.Дөлгөөн, гадуур тэнэдэг М.Мөнх-Ану, бусдад амархан уруу татагдаж болзошгүй сурагчдын судалгаа авч, дүн шинжилгээ хийж, эцэг эхтэй хамтран ажилласнаар тус сурагчид гадуур тэнэх, РС тоглох явдал зогссон.
10. Хяналтын хуудасны хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийсэн байдал
- Анги хамт олон, сурагч бүр аливаа үйл ажиллагаанд оролцсон үнэлгээг өөрсдөөр нь хийлгэх, түүндээ дүгнэлт хийх чадварт сургахыг зорин ажиллалаа.
- V. Эрүүл мэнд
1. Мэндлэх хүндлэх-зөв боловсон харилцаа
- Багш, ажилчидтай мэндлэх
 - Тэдний хийж байгаа ажлыг хүндэтгэн харилцах
 - Багш, сурагчийн хооронд эрүүл харилцааг бүрдүүлэхэд чиглэн ажиллалаа.
 - Ангийн жижүүрийг ухамсарлан хийх, өөрсдийн сурч байгаа орчингоо цэвэр тохитой байлгах тал дээр тогтмол шаардлага тавин ажилласан /ангийн ариун цэврийн асуудал/
2. Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж, үлгэрлэсэн байдал
- Бага ангийн сурагчдад хичээлийн дундуур алжаал тайлах хөдөлгөөнт шүлгэн дасгал хийлгэж хэвшүүлсэн.
 - 4-р цагийн завсарлагаанаар сурагчдын хамт гимнастик хийж хэвшсэн
 - Сурагчид өдөр бүр суудлаа хойноосоо урагш урсан сууснаар тэдний хичээлд оролцох идэвхи сайжирсан.
 - Зөв, тэгш суухыг зөвлөдөг.
 - Дүрэмт хувцас бүрэн өмсөх
 - Охидууд сургууль дээр үсээ тогтмол бооход анхаарч шаардлага тавин хэвшүүлсэн.
 - Сурагчдын өндөр, жин үзэх үзлэгт хуваарийн дагуу хамруулсан.
 - Ангийн 44-43 сурагч улаан бурхан өвчний вакцинд хамрагдсан.
 - Ангийн эд хогшил, ширээ сандлыг ариг гамтай эдэлж хэрэглэхэд анхаарсан. Ангийн сурагчид өөрсдийн хэрэглэж буй ширээ сандлаа хариуцсан.
 - 7 хоног бүрийн бямба гаригт смен бе ангитай ээлжлэн их цэвэрлэгээ хийж заншсан.
3. Эрүүл орчинд байхын ач тусын талаар ойлголт өгч, хэвшил болохуйц ажил зохион байгуулж, үр дүнд хүрсэн байдал
- Улаан бурхан, улаанууд өвчнөөс урьдчилан сэргийлэх 10-18 насны хүүхдэд хийх нэмэлт дархлаажуулалтын вакцин хийх улс орон даяар явагдаж буй аяны талаар мэдээлэл
 - Охидын эмч Баярмаагийн зөвлөмж, хичээл
 - Олон улсын хэрэглэгчийн эрхийн өдөр-Ухаалаг аюулгүй бараа бүтээгдэхүүн PPT хичээл

- Менингит өвчний тухай, түүнээс урьдчилан сэргийлэх арга замууд зурагт хуудас, зөвлөмж
- Томуу, томуу төст өвчний үед анхаарах зүйлс зөвлөмж зэрэг мэдээллийг эцэг эх, сурагчдад хүргэж ажиллалаа.

8а анги:



“Цайны их замаар” ОУ-ын хүүхдийн наадамд 8а ангийн сурагчид илтгэл, IQ, ардын бүжгийн төрлөөр оролцон мөнгө, хүрэл медаль хүртлээ.



Замын цагдаагийн газрын нээлттэй хаалганы өдөр, “Бяцхан зорчигч” аяны үйл ажиллагаанд оролцлоо.



2-р нэгдсэн эмнэлгийн эмч Баярмаа эрүүл ахуй,
төлөвшил хандлагын хичээл явууллаа.



Физикийн улсын багийн олимпиадын
хүрэл медаль